



Ш.ЭНХЖАРГАЛ

*Хууль сахиулахын их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Иргэний болон захиргааны шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн
тэнхимийн багш, ахмад*

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДЛЫН ЭРГЭН ТӨЙРОНД

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн хөгжлийн үйл явдлаас харахад 1996 онд шүүхийн тогтоол гүйцэтгэгч нарыг Хорих байгууллагыг удирдах газартай нэгтгэн эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол болон иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага үүсч байгуулагдсан түүхтэй.

Өнөөгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын салаа мөчир болон ургасан Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий Шийдвэр гүйцэтгэх газрын бүтцийн анхан шатны нэгжид ажиллаж буй алба хаагчид нь шийдвэр гүйцэтгэгч нар юм.

Шийдвэр гүйцэтгэгч нар нь төрийг төлөөлж, хууль сахиулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулдгийн хувьд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрхийг хүндэтгэн хамгаалах зарчмыг ямагт мөрдөн ажиллах шаардлага тулгардаг.

Ер нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын онцлог нь эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн харилцааны үргэлжлэл бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн мэргэжлийн ур чадвар, ухааныг гарган шийдвэрлэсэн хэргийн биелэлтийг хангуулах буюу эцсийн шат дамжлагыг гүйцэтгэх хариуцлагатай үүргийг гүйцэтгэдэг байгууллага юм.

Энэхүү онцлог үйл ажиллагаатай холбогдуулан шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаа нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, тогтоол, захирамжийг биелүүлэх явцад иргэн, байгууллага, хуулийн этгээдүүдтэй харьцах шаардлага байнга тулгардаг.

Нэг талаараа шийдвэр гүйцэтгэгчийн үйлдэл нь хохирсон иргэн, байгууллага, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалан зөрчигдсөн эрхийг

нь сэргээж, хохирлыг барагдуулж байгаа боловч, нөгөө талаараа иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хөндөн, эд хөрөнгө, эрхэд халдах албадлагын үйл ажиллагааг явуулж байдгаараа ихээхэн бэрхшээлийг туулах шаардлага тулгардаг.

Ийм ч учраас шийдвэр гүйцэтгэгч нарын хувьд үйл ажиллагаагаа бие даасан, үр дүнтэй явуулах эрх зүйн болон нийгмийн баталгааг төрөөс бүрдүүлж өгөх шаардлага зүй ёсоор тавигддаг. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг заасан байдаг бөгөөд мөн Төрийн албаны тухай хуулиар эрх зүйн баталгааг бүрдүүлэн зохицуулсан байдаг. Шийдвэр гүйцэтгэгч нь төрийн нэрийн өмнөөс хүлээсэн үүргээ биелүүлэх явцад эрх зүйн баталгаа, хамгаалалт дутмагаас шийдвэр гүйцэтгэгчийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд халдах тохиолдолд цөөнгүй гардаг.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд халдлагад өртсөн шийдвэр гүйцэтгэгч нарын судалгааг үзвэл:

2010 онд 5 тохиолдол,

2011 онд 2 тохиолдол,

2012 онд 6 тохиолдол,

2013 онд 10 тохиолдол,


2014 онд 1 тохиолдол бүртгэгдсэн байна⁷⁹

Эдгээрийг зөрчлийн төрлөөр ангилж үзвэл:

Он	Хэл амаар доромжлуулж, цохиулсан	Х?нг?н зэргийн гэмтэл учруулсан	Хувцсаа уруулсан	Нохойд уруулсан
2010	1	4	0	0
2011	1	1	0	0
2012	4	1	0	1
2013	5	3	1	1
2014	0	1	0	0

Харин эдгээр зөрчлийг шийдвэрлэсэн байдлыг үзвэл:

⁷⁹ Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны мэдээгээр



Энэхүү судалгаанд шийдвэр гүйцэтгэгч нарт өдөр тутам тохиолддог саад, бэрхшээлийг оруулбал маш их дүн мэдээ гарах болно.

Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын онцлогоос шалтгаалан тэдгээрийн халдашгүй байдал, аюулгүй байдлыг хамгаалах асуудал хамгийн чухлаар тавигддаг. Хамгийн сүүлийн ноцтой жишээ нь 2013 онд Сүхбаатар аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч С нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны явцад тэтгэлэг төлөгчид буудуулж амь насаа алдсан. Золгүй явдлын үеэр шийдвэр гүйцэтгэгч нэг бүрийн тусгай хэрэгслээр хангагдаагүй, онцгой нөхцөл байдлын үед биеэ хамгаалах, арга хэмжээ авах төлөвлөгөө, туршлага байгаагүй нь гэмт хэргийн хохирогч болох шалтгаан нөхцөл болсон.

Шийдвэр гүйцэтгэгчид эдийн засаг, нийгмийн баталгаанаас гадна хамгийн чухал нь шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны үед хөндлөнгөөс бусад этгээд оролцохгүй саад учруулахгүй байх, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны дагуу тавьсан шаардлагыг тухайн этгээд заавал биелүүлэх, албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан хуульд заасан нөхцөл шаардлагад нийцүүлэн биелүүлснээс үүдэх үр дагаврыг шийдвэр гүйцэтгэгч өөрөө хариуцахгүй байх зэрэг эрх мэдлийн эрх зүйн баталгаагаар хангагдах шаардлага тулгарч байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа сэтгэцийн янз бүрийн хэв шинжийн хүмүүстэй тулгардаг. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэгчийн биед халдах эсхүл төлбөр төлөгч, гуравдагч этгээд амиа хорлох, биедээ гэмтэл учруулахыг завдах тохиолдол их гардаг. Энэ үед шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс нөхцөл байдлыг үнэлэн, өөрт болон бусад этгээдэд аюул учруулахгүйгээр арга хэмжээг авах чадвар, дадалд сурах нь зүй ёсоор тавигдаж байна.

Мөн шийдвэр гүйцэтгэгч нар эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг чадварыг эзэмшсэн байх шаардлагатай бөгөөд, энэ чиглэлийн

сургалтыг байнга явуулж байх шаардлагатай байна.

Энэхүү илтгэлийг дүгнэн, цаашид шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шийдвэр гүйцэтгэгчид эдийн засгийн болон нийгмийн баталгаанаас гадна эрх мэдлээ хэрэгжүүлэх явцад халдашгүй байх эрх зүйн баталгаагаар хангагдах /Тухайлбал шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын улмаас биеэ хамгаалах зорилгоор тусгай хэрэгсэл хэрэглэсэн, эрх мэдлээ хэрэгжүүлсэн байдлаас шалтгаалан аливаа хариуцлага хүлээхгүй байх гэх мэт/

2. Сэтгэцийн янз бүрийн хэв шинжийн хүмүүстэй ажиллах, нөхцөл байдлыг үнэлэх, тухайн цаг үеийн байдалд тохируулан арга хэмжээ, хариу үйлдэл хийх чадварыг сургах

3. Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвартай болгох

4. Шийдвэр гүйцэтгэгчийн хэрэглэх нэг бүрийн тусгай хэрэгслийн тоог нэмэгдүүлэх / жишээлбэл: цахилгаан бороохой, сум нэвтэрдэггүй хантааз гэх мэт хэрэгслийг тусгай хэрэгслийн тоонд нэмж оруулах/ шаардлагатай байна.